



# СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

## “БУЛИГААР” ХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар  
2025 он

**АГУУЛГА**

**ХУУДАС**

КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ .....	1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН .....	2-4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН .....	5
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН .....	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН .....	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН .....	8
ТАЙЛАГНАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ .....	9
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГЫН ХУРААНГУЙ.....	9-22
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	22-30
ГЭРЭЭТ АЖЛЫН ЗАХИДАЛ.....	31-32
ГЭРЭЭТ АЖЛЫН ЗӨВЛӨМЖИЙН ҮРГЭЛЖЛЭЛ.....	33-34



**“БУЛИГААР” ХК-ийн товч мэдээлэл:**

<b>Албан ёсны хаяг:</b>	Монгол Улс, Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө - 5 өөрийн байранд
<b>Гүйцэтгэх захирал:</b>	Б.Батгүшиг
<b>Харилцагч банкууд:</b>	Капитрон банк Хаан банк Төрийн банк
<b>Аудитын компани:</b>	<b>Сэрэлт Дөл Аудит ХХК</b>
<b>Үйл ажиллагааны зөвшөөрөл:</b>	Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны <b>23-2015</b> дугаарын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2024 оны 12-р сар хүртэл сунгуулсан.
<b>Албан ёсны хаяг:</b>	УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын гудамж, Peace building . 302 тоот



“БУЛИГААР” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;  
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2025.02.26 № С 714/25-39  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “Булигаар” ХК-ний 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага(үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь Шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)**

✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

**Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу “Булигаар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2025 оны 2 сарын 26



**ДАЛТАНЦЭЦЭГ**  
Захирал, ММНБ



**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тод	2023.12.31	2024.12.31	Аудитлагдсан 2024.12.31
<b><u>Эргэлтийн хөрөнгө</u></b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	22,914,287.62	27,783,750.44	14,182,297.87
Дансны авлага	6	1,448,581,679.48	1,117,927,015.72	660,227,750.18
Татвар НДШ-ийн авлага		3,997,578.54		
Бусад авлага	6	7,992,803,366.45	6,644,652,686.21	8,525,397,517.89
Бараа материал	7	5,015,778,458.74	5,359,341,850.37	4,999,651,253.55
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		932,013,269.49	932,013,269.49	
		<b><u>15,416,088,640.32</u></b>	<b><u>14,081,718,572.23</u></b>	<b><u>14,199,458,819.49</u></b>
<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>				
Үндсэн хөрөнгө	8	18,181,826,453.62	17,790,151,095.71	17,342,740,670.94
Биет бус хөрөнгө	9	359,473,988.31	338,264,752.83	316,822,448.81
Хойшлогдсон татварын хөрөнгө			540,771,360.38	588,301,125.38
		<b><u>18,541,300,441.93</u></b>	<b><u>18,669,187,208.92</u></b>	<b><u>18,247,864,245.13</u></b>
<b><u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u></b>				
		<b><u>33,957,389,082.25</u></b>	<b><u>32,750,905,781.15</u></b>	<b><u>32,447,323,064.62</u></b>
Дансны өглөг	10	1,894,388,915.54	5,832,758,370.19	1,676,898,034.72
Татварын өр	10	607,120,610.30	254,043,852.64	234,024,057.44
НДШ-ийн өглөг		539,482,718.25	187,518,949.33	187,518,949.33
Богино хугацаат зээл	10	905,627,293.53	2,283,352,119.45	747,921,236.45
Хүүний өглөг	10	137,996,091.97		47,807,587.42
Ногдол ашгийн өглөг		13,053,235.72		
Урьдчилж орсон орлого		647,564,387.27	647,564,387.27	
Бусад богино хугацаат өр төлбөр		1,148,046,324.59		5,168,884,441.15
		<b><u>5,893,279,577.17</u></b>	<b><u>9,205,237,678.88</u></b>	<b><u>8,063,054,306.51</u></b>
<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>				
Урт хугацаат зээл		4,527,771,694.27		1,535,430,883.00
Бусад урт хугацаат өр төлбөр		11,873,573,618.8	11,877,094,739.96	11,873,573,618.87
		<b><u>16,401,345,313.14</u></b>	<b><u>11,877,094,739.96</u></b>	<b><u>13,409,004,501.87</u></b>
<b><u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u></b>				
		<b><u>22,294,624,890.31</u></b>	<b><u>21,082,332,418.84</u></b>	<b><u>21,472,058,808.38</u></b>
Хувийн өмч/ хувьцаат/	11	40,021,200.00	40,021,200.00	40,021,200.00
Халаасны хувьцаа				
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		9,866,281,421.12	9,866,281,421.12	8,308,751,508.03
Эздийн өмчийн бусад хэсэг		266,001,000.00	266,001,000.00	266,001,000.00
Хуримтлагдсан ашиг		1,490,460,570.82	1,496,269,741.19	2,360,490,548.21
		<b><u>11,662,764,191.94</u></b>	<b><u>11,668,573,362.31</u></b>	<b><u>10,975,264,256.24</u></b>
<b><u>Эздийн өмчийн дүн</u></b>				
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b><u>33,957,389,082.25</u></b>	<b><u>32,750,905,781.15</u></b>	<b><u>32,447,323,064.62</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

**/төгрөгөөр/**

Үзүүлэлт	Тод	2023.12.31	2024.12.31	Аудитлагдсан 2024.12.31
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	12	<b><u>7,206,952,818.04</u></b>	<b><u>8,628,360,304.68</u></b>	<b><u>8,628,311,765.90</u></b>
Борлуулалтын өртөг	13	5,406,101,132.94	4,932,896,321.00	7,381,077,650.94
<b>Нийт ашиг /алдагдал/</b>		<b><u>1,800,851,685.10</u></b>	<b><u>3,695,463,983.68</u></b>	<b><u>1,247,234,114.96</u></b>
Түрээсийн орлого				3,720,000.00
Хүүний орлого				53,950.03
Ногдол ашгийн орлого				
Бусад орлого		2,546,851.80		1,730,000.01
Борлуулалт, маркетингийн зардал	14	131,569,150.24		176,486,201.97
Ерөнхий ба удирдлагын зардал	14	1,597,512,947.71	3,689,009,349.92	969,844,219.12
Санхүүгийн зардал				
Бусад зардал	15	7,983,340.68		392,340.44
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	16	-24,261,907.63		-94,336.49
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)				
Бусад ашиг (алдагдал)				
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b><u>42,076,745.27</u></b>	<b><u>6,454,633.76</u></b>	<b><u>105,920,966.98</u></b>
Орлогын татварын зардал	17	6,804,456.19	645,463.38	10,409,811.12
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b><u>35,272,289.08</u></b>	<b><u>5,809,170.38</u></b>	<b><u>95,511,155.86</u></b>
<b>Орлогын нийт дүн</b>		<b><u>35,272,289.08</u></b>	<b><u>5,809,170.38</u></b>	<b><u>95,511,155.86</u></b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</b>				

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.0	9,848,154,758.8	266,001,000.0	3,565,016,400.6	13,719,193,359.4
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	40,021,200.0	9,848,154,758.8	266,001,000.0	3,565,016,400.6	13,719,193,359.4
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				35,272,289.1	35,272,289.1
Дахин үнэлгээний нэмэгдэлийн дүн					
Зарласан ногдол ашиг				(100,053,000.0)	(100,053,000.0)
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.0	9,848,154,758.8	266,001,000.0	3,500,235,689.7	13,654,412,648.5
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	40,021,200.0	9,848,154,758.8	266,001,000.0	3,500,235,689.7	13,654,412,648.5
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				95,511,155.9	95,511,155.9
Өмчид гарсан өөрчлөлт				774,518,821.5	774,518,821.5
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,557,529,913.1)			(1,557,529,913.1)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.0	8,290,624,845.7	266,001,000.0	4,370,265,667.1	12,966,912,712.8

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**/төгрөгөөр/**

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31	Аудитлагдсан 2024.12.31
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>6,628,951,406.15</u></b>	<b><u>16,938,611,190.65</u></b>	<b><u>12,297,336,820.62</u></b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,557,976,210.16	16,938,611,190.65	8,933,019,518.15
Бусад мөнгөн орлого	70,975,195.99		3,364,317,302.47
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b><u>6,376,715,307.00</u></b>	<b><u>15,756,288,550.76</u></b>	<b><u>8,542,568,865.60</u></b>
Ажиллагчдад төлсөн	1,054,944,045.98	929,631,232.99	968,606,602.70
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	180,000,000.00	606,436,057.91	606,436,057.91
Бараа материал худалдан авахад төлсөн	2,583,335,083.06	5,300,687,710.32	4,053,680,137.76
Ашиглалтын зардалд төлсөн	792,559,010.33	1,145,796,678.45	1,106,978,782.40
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	534,664,178.57	210,904,645.23	428,639,345.68
Хүүний төлбөрт төлсөн	492,317,647.04	568,950,123.00	402,402,546.34
Татварын байгууллагад төлсөн	370,200,043.70	1,205,272,824.22	499,030,989.94
Даатгалын төлбөрт төлсөн	633,794.00	5,788.00	238,275.00
Бусад мөнгөн зарлага	368,061,504.32	5,788,603,490.64	476,556,127.87
<b>ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний Мөнгөн орлогын дүн</b>	<b><u>30,250,511.50</u></b>	<b><u>1,182,322,639.89</u></b>	<b><u>3,754,767,955.02</u></b>
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт	15,244,577.60		57,510.30
Хүлээн авсан хүүний орлого	5,933.90		57,510.30
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	15,000,000.00		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b><u>227,121,534.45</u></b>	<b><u>591,649,210.59</u></b>	<b><u>334,293,260.15</u></b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	85,145,230.58	591,649,210.59	334,293,260.00
Бусдад олгосон зээл урьдчилгаа	141,976,303.87		
<b>ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b><u>-196,871,022.95</u></b>	<b><u>-591,649,210.59</u></b>	<b><u>-334,235,749.85</u></b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>3,908,420,776.74</u></b>	<b><u>1,700,000,000.00</u></b>	<b><u>1,793,935,000.00</u></b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,908,420,776.74	1,700,000,000.00	1,793,935,000.00
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b><u>3,962,207,868.77</u></b>	<b><u>2,285,803,966.48</u></b>	<b><u>5,219,330,998.48</u></b>
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,866,427,189.49	2,285,803,966.48	5,205,483,914.71
Төлсөн ногдол ашиг	86,999,764.28		
Бусад мөнгөн зарлага	8,780,915.00		13,847,083.77
<b>СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b><u>-53,787,092.03</u></b>	<b><u>-585,803,966.48</u></b>	<b><u>-3,425,395,998.48</u></b>
Валютын ханшийн зөрүү	<b><u>-3,656,681.32</u></b>		<b><u>-3,868,196.44</u></b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b><u>-2,078,697.15</u></b>	<b><u>4,869,462.82</u></b>	<b><u>-8,731,989.75</u></b>
<b>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b><u>24,992,984.77</u></b>	<b><u>22,914,287.62</u></b>	<b><u>22,914,287.62</u></b>
<b>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b><u>22,914,287.62</u></b>	<b><u>27,783,750.44</u></b>	<b><u>14,182,297.87</u></b>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

## 1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Булигаар” ХК (цаашид “Компани” гэх) нь 2008 онд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн голлох хувьцаа эзэмшигчид нь А.Энхмэнд, Б.Анхболд, Б.Баянжаргал, бусад 818 хувьцаа эзэмшигч нар болно.

Гүйцэтгэх захирлын нэр: Б.Баттүшиг  
Хувьцааны төрөл: Энгийн  
Үйл ажиллагааны чиглэл: Гадаад худалдаа, Арьс шир боловсруулалт, худалдаа, Гутлын дээд биений материал үйлдвэрлэх, Худалдааны зуучлал

Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, өөрийн байранд гэсэн албан ёсны хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

УБ-ийн гэрчилгээ : 9010001072 тоот  
Регистрийн дугаар: 2039184 тоот

### Өмчийн хэлбэр:

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүрийн 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 400,212,000.00 мянган төгрөгийн хувьцаатай байна.

### Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл:

№	Овог нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	А.Энхмэнд	ТУЗ-ийн гишүүн	39.14%
2	Б.Анхболд	ТУЗ-ийн гишүүн	36.48%
3	Б.Баянжаргал	ТУЗ-ийн гишүүн	12.49%
4	Бусад 818 хувьцаа эзэмшигч	ТУЗ-ийн гишүүн	11.89%

Тайланг хамарсан хугацаа: 2024 оны 1дүгээр сарын 1-нээс 2024 оны 12 дугаар сарын 31



## 2. **НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### 2.1 Компанийн ногдол ашиг тараах шийдвэр

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн №03/25 тоот тогтоолоор 2024 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилгод түвшинд хүрээгүй, ногдол ашиг хуваарласны дараа компанийн төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул хувыцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

## 3. **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй**

### 3.1 Санхүүгийн тайланг бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан бодлого журам, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

### 3.2 Тайлангийн мөнгөн тэмдэгт

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байна.

### 3.3 Үйл ажиллагааны ба толилуулга

Санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү Аудитлагдсан санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх оны аудитлагдсан үлдэгдэлтэй зэрэгцүүлсэн.

### 3.4 Тасралтгүй байх зарчим

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн цэвэр эргэлтийн хөрөнгө нь 6,136,404,513.0 төгрөг, (2023: 9,522,809,063.2) төгрөг байна. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйн ашигтай үйл ажиллагаа, эерэг мөнгөн урсгал ба эсвэл хувь нийлүүлэгчдээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэхээс хамаарна.

Тус компани нь “Смарт ложик” ХХК-ийн “Смарт” программ ашигладаг.

### 3.5 Удирдлагын тооцоолол ба шийдэл

Санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь удирдлагын тооцоолол, шийдэл гаргахыг шаарддаг ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнд нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

### 3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт

2024 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2024.01.01	СТОУС-16 Түрээс Борлуулах ба буцаан түрээслэхтэй холбоотой хувьсах төлбөрийн өөрчлөлт
2024.01.01	НББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, эргэлтийн бус өр төлбөрийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагын талаарх өөрчлөлт
2024.01.01	НББОУС-7 Мөнгөн гүйлгээний тайлан, СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын нэмэлт өөрчлөлтүүд
2024.01.01	СТОУС-ТБ1 Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага
2024.01.01	НББОУС-21 Гадаад валютын ханшийн үр нөлөө Арилжааны алдагдлын талаарх нэмэлт өөрчлөлт

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

### 3.7 Гадаад валютын өөрчлөлт

Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (Гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэсэн. Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр төлөгдөх эсвэл хөрвүүлэх үед үүссэн бүх зөрүү нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдана. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээ хийсэн өдрийн ханшаар бүртгэнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Мөнгөн бус мэдээллийн өөрчлөлттэй холбоотой ашиг, алдагдал боломжийн үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдалтай харьцуулна. (Тухайлбал: бодит үнэ цэнийн олз, гарз нь “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д, бүртгэгдсэн зүйл дээр ханшийн хөрвүүлэлтээс үүсэх олз, гарз нь мөн адил “Бусад дэлгэрэнгүй орлого эсвэл ашиг, алдагдал”-д тус тус бүртгэгдэнэ.)

Төгрөгийн нэгж ам доллартай харьцах ханш 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 ам доллар = 3,420.46 төгрөг (2023: 1 ам доллар=3,410.69 төгрөг).



### **3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

#### **3.8 Орлого хүлээн зөвшөөрөх**

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээс хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татвар эсвэл хураамжийг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тодорхой хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан байх ёстой.

#### **Түрээсийн орлого**

Үйл ажиллагааны түрээсээс үүсэх орлогыг нийт түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

#### **Харилцагчтай байгуулсан гэрээний орлого**

Компани тайлант онд харилцагчтай байгуулсан гэрээний орлогыг бараа, үйлчилгээний хяналт харилцагчид шилжсэн үед харилцагчаас авахаар хүлээгдэж буй бараа үйлчилгээний төлбөрийн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

#### **Борлуулсан барааны болон үйлчилгээний өртөг**

Борлуулсан барааны өртөг нь тухайн барааны эрсдэл нь худалдан авагч талд шилжсэн үед буюу бараа материалыг худалдан авагчид өгсөн үед хүлээн зөвшөөрөгдөнө. Борлуулсан барааны орлого нь барааны оронд хүлээн авсан болон хүлээн авах авлагаас буцаалт болон хөнгөлөлт мөн хямдрал болон их хэмжээний худалдан авалтын урамшууллыг хассан бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

#### **Шимтгэлийн борлуулалтын орлого**

Шимтгэлийн борлуулалтын орлого нь худалдааны зуучлах үйл ажиллагаа хэрэгжих үед хүлээн зөвшөөрөгдөнө.

#### **Хүүгийн орлого**

Хүүгийн орлогыг бүртгэхдээ үр ашигт хүүний арга ашиглан бүртгэнэ. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд хүлээгдэж буй орох, гарах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэгслийн эргэн төлбөр хийх хугацаа ба түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг бодитойгоор тооцох хүү юм.

#### **Зардлууд**

Зардлууд нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийн бууралт (хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос бусад бууралт) - ыг үүсгэж буй эдийн засгийн үр ашгийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, өр төлбөрийн нэмэгдлээс үүснэ. Ерөнхий болон удирдлагын зардал, борлуулсан барааны өртөг, бусад зардал, санхүүгийн зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.



### **3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

#### **Түрээсийн зардал**

Тухайн гэрээ нь түрээсийн эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулгад үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх болон гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай Компани нь түрээслэгч үед үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ.

#### **Зээлийн зардал**

Хөрөнгийн худалдан авалт, бүтээн байгуулалт эсвэл төлөвлөсөн зориулалт эсвэл борлуулахад бэлэн болгоход ихээхэн хэмжээний цаг хугацаа шаарддаг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулдаг. Бусад зээлийн зардал нь зардал гарсан тайлант хугацааны зардлаар бүртгэгдэнэ. Зээлийн зардалд хүү болон Зээлтэй холбоотой байгууллагаас гарсан бусад бүх зардлыг оруулан тооцдог.

#### **Богино хугацааны тэтгэмж**

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

#### **Заавал төлөх даатгалын шимтгэлүүд**

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө. Компани хуулинд зааснаас өөр тэтгэвэр болон бусад тэтгэмжийн хөтөлбөрт төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

#### **Тайлант хугацааны орлогын албан татвар**

Компани нь Монгол Улсын Засгийн газрын дүрэм журмын дагуу татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог. Тайлант хугацааны болон өмнөх тайлант жилүүдийн орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас авахаар эсвэл тэдгээрт төлөхөөр хүлээж буй дүнгээр хэмжсэн. Эдгээр дүнг тооцоход ашигласан татварын хувь хэмжээ ба татварын хуулиуд нь тайлант хугацааны эцэст хүчин төгөлдөр үйлчилж байсан.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

#### Хойшлуулсан албан татвар

Санхүүгийн байдлын тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Өр төлбөрийн арга"-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөр нь түр зөрүүнд хүлээнд зөвшөөрөгдөнө. Хойшлогдсон албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайпант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр өөрийн хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй, хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тайлагналын өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эсвэл үйлчилж хараахан эхлээгүй байгаа татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах, тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь татвар төлөгч нэг аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон орлогын татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

#### Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал ба хөрөнгө нь НӨАТ-ын дүнг хассан цэвэршсэн дүнгээр хүлээн зөвшөөрөгдөнө. Үүнд:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Борлуулалт худалдан авалттай холбоотой НӨАТ нь санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгдөх ба өөрөөр хэлбэл НӨАТ-ын авлага болон өглөгийн цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайлангийн өглөг эсвэл авлагын хэсэгт тусгагддаг. Авлагын үнэ цэнийн бууралтанд нөөц байгуулсан тохиолдолд харилцагч талаас авах НӨАТ агуулсан нийт дүнгээс тооцсон байна.



### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

#### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцож тусгана. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, импортын татвар, татварууд болон хөрөнгийг ашиглалтанд оруулахтай холбогдон гарсан шууд зардлууд орно.

Үндсэн хөрөнгө анх үнэлж байсан стандарт гүйцэтгэлээс илүү гарч түүнийг ашиглахтай холбогдон гарсан зардал ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг өсгөсөн нь тодорхой болсон бол зардлыг үндсэн хөрөнгийн нэмэлт өртгөөр капиталжуулна.

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасах үед тухайн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын дүнг оролцуулан данснаас хасах бөгөөд үүнээс үүсэх аливаа олз, гарзыг тайлант жилийн орлого, үр дүнгийн тохирох хэсэгт бүртгэнэ.

№		Ашиглах нийт хугацаа /жилээр/	
	Хөрөнгийн бүлэг	Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд	Бусад
1	Барилга байгууламж, газрын тохижилт	40	25
2	Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10	
3	Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж	2	
4	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд	
5	Бусад хөрөнгө	10	

МУ-ын Татварын хуулинд Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно гэсэн заалт байдаг боловч тухайн байгууллага элэгдэл тооцох ямар аргыг хэрэглэж байгаагаа өөрийн байгууллагын НБББодлогодоо тусган өгч зөрүүг Татвар Санхүүгийн тайлангийн зөрүүг зохицуулах журмын дагуу зохицуулж явна.

#### Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно.) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.



### **3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

#### **Биет бус хөрөнгө (үргэлжлэл)**

Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарз нь цэвэр борлуулалтын орлого болон хөрөнгийн бүртгэлийн үнийн зөрүүгээр хэмжигдэх ба олз, гарзыг биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед орлого, зардлын дансанд бүртгэнэ. Компанийн биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамжийн лицензүүд байх бөгөөд хүлээгдэж буй гурваас (3) арван (10) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

#### **Бараа материал**

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

#### **Урьдчилгаа төлбөр**

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалаа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ.

Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдал руу, бараагаа хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө руу ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах болон урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

#### **Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Үнэ цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илрэх үед болон хөрөнгийн (бараа материал болон санхүүгийн хөрөнгөөс бусад) бүртгэлийн дүнгүүд үнэ цэнийн бууралт агуулж буй эсэхийг шалгах шаардлагатай болсон тохиолдолд хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно.

Хөрөнгийн нөхөгдөх дүн нь хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба түүний бүртгэлийн дүн хоёрын аль өндөр нь байх бөгөөд хөрөнгө нь бусад хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгөөс хамааралгүйгээр мөнгөн урсгалыг бий болгохгүй байвал хөрөнгө нэг бүрийн нөхөгдөх дүнг тодорхойлно.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг зөвхөн хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөнд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

### **3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

#### **Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зохих (үнэ цэнэ нь буурсан хөрөнгийн ажиллагаанд хамаарагдах) зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцоолуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүн) - гээс хэтрэхгүй байна. Ийм буцаалтыг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

#### **Санхүүгийн хэрэглүүр**

##### *Санхүүгийн хөрөнгө*

Компанийн санхүүгийн хөрөнгө нь бусад авлага болон касс ба харилцах данс дахь бэлэн мөнгө зэргээс бүрдэх бөгөөд зээл ба авлага гэж ангилагддаг. Санхүүгийн хөрөнгийг арилжаа хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрнө.

Зээл болон авлагууд нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм. Анхны хэмжилтийн дараа эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн хорогдлын дүнг үр ашигт хүүний арга ашиглан гаргадаг ба түүнээс үнэ цэнийн бууралтыг хасаж өгдөг. Хорогдуулалт нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд багтана. Үндсэн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан эсвэл эрхээ шилжүүлэн өгсөн, Компани нь тухайн хөрөнгийн эрсдэл болон өгөөжийг шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

#### **Санхүүгийн өр төлбөр**

Компанийн санхүүгийн өр төлбөрт дансны болон бусад өр төлбөрүүд багтана. Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн оролцогч тал болох үед санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Анх хэмжээний дараа, санхүүгийн өр төлбөрийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрнө.

#### **Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ.**

Боломжийн үнэ гэдэг нь: хөрөнгөө борлуулаад хүлээн авч болох үнэ эсвэл хэмжилтийн огнооны зах зээлийн оролцогчийн хооронд хийсэн өр төлбөрийг шилжүүлэн төлөх үнэ юм.



### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

#### Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Боломжийн үнийн хэмжилт нь таамаглал дээр суурилсан байх бөгөөд хөрөнгө борлуулсан гүйлгээ эсвэл өр төлбөрийн шилжүүлэг юм.

- Хөрөнгө болон өр төлбөрийн үндсэн зах зээл
- Үндсэн зах зээл байхгүй нөхцөлд хөрөнгө, өр төлбөрийн хамгийн ашигтай зах зээлд Компани нь үндсэн эсвэл хамгийн ашигтай зах зээлийг хэрэглэх боломжтой байна.

Хөрөнгө эсвэл өр төлбөрийн боломжийн үнэ нь хөрөнгө эсвэл өр төлбөрийг үнэлэж байгаа болон эдийн засгийн хамгийн сайн зах зээлийн оролцогч байдлаар ашиглагдаж хэмжигдэнэ. Санхүүгийн бус хөрөнгийн боломжийн үнийн хэмжилт нь хамгийн өндөр, хамгийн сайн борлуулалтыг ашиглан өөр зах зээлийн оролцогчид борлуулж эдийн засгийн ашиг хүртэх боломжтой зах зээлийн оролцогчийн авч үздэг. Компани нь боломжийн үнийг тодорхойлох хангалттай мэдээлэл байгаа нөхцөлд мэдэгдэхүйц зардлыг дээд хязгаарт хүртэл өсгөж мэдэгдэхгүй зардлыг бууруулах байдлаар үнэлгээний техникийг ашигладаг. Боломжийн үнийн бүхий л хөрөнгө болон өр төлбөр нь шатлан захирах үнэлгээний хүрээнд санхүүгийн тайланд илэрхийлэгддэг бөгөөд боломжийн үнийн үнэлгээ нь хамгийн доод түвшинд суурилсан байдаг.

- 1-р түвшин: Хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн үнэлэсэн (тохируулаагүй) зах зээлийн үнэ
  - 2-р түвшин: Шууд болон шууд бус байдлаар илэрхийлэгдэх боломжийн үнийн үнэлгээнд чухал ач холбогдолтой хамгийн бага түвшиний үнэлгээний техникүүд
  - 3-р түвшин: Бүртгэсэн бодит үнэ цэнд томоохон нөлөө үзүүлэх, ажиглаж үл болохуйц зах зээлийн өгөгдөл дээр суурилсан өгөгдлүүдийг ашигладаг техникүүд
- Санхүүгийн тайлангуудад байнга хүлээн зөвшөөрөгддөг хөрөнгө, өр төлбөрийн хувьд Компани нь тайлант хугацааны эцэс бүрд ангиллыг дахин үнэлэн (бодит үнэ цэнийн хэмжилтэд бүхлээрээ үзүүлэх нөлөөний түвшинд суурилан) түвшингүүдийн хооронд шилжилт байгаа эсэхийг тодорхойлдог.

#### Эздийн өмч

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгийн ангилалд оруулна. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчийн дүнд тусгадаг.

Хувьцааг нэмэгдэлтэй зарсан тохиолдолд нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг хувьцааны нэмэгдлээр бүртгэнэ.

Хувьцааны нэмэгдэлд мөн хувьцаа эзэмшигчдийн оруулсан нэмэлт хөрөнгө оруулалт багтана.

#### Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд бэлэн мөнгө ба банкны үлдэгдэл нь банкинд бэлэн мөнгөөр хийгддэг.



### **3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

#### **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (үргэлжлэл)**

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгөн хөрөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө ба үнэ цэнэ нь өөрчлөгдөх эрсдэл багатай банкуудад хамаарна.

#### **Хуримтлагдсан ашиг**

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлаас зарласан ноогдол ашгийг хассан дүнг илэрхийлнэ.

#### **Сангууд**

Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Компани нь байгуулсан сангийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нь нөхөн төлбөрт зарцуулахаар хүлээж байгаа үед (жишээ нь: даатгалын гэрээний үед), нөхөн төлбөр хийх нь бодитой болсон үед л зөвхөн нөхөн төлбөрийг тусдаа хөрөнгө болгон хүлээн зөвшөөрнө. Аливаа сантай холбоотой зардлыг орлого үр дүнгийн тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

#### **Болзошгүй өр төлбөр**

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй ба хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшаа урсах боломжгүй биш л бол эдгээр өр төлбөрийн талаар санхүүгийн тайланд тодруулга хийж өгнө.

#### **Тайлагналын дараах үйл явдлууд**

Тайлагналын хугацааны эцэс дэх Компанийн санхүүгийн байдал (залруулах үйл явдлын тухай) нэмэлт мэдээллийг гаргаж өгдөг жилийн эцсийн үйл явдлыг санхүүгийн тайланд тусгана. Залруулга шаардахгүй, материаллаг хэмжээтэй, тайлант хугацааны дараах үйл явдлуудыг санхүүгийн тайланд тодруулж өгнө.

#### **Холбоотой талууд**

Холбоотой тал гэдэг нь: Компанитай холбоотой этгээд юмуу эсвэл компани юм.

Тухайн хүний эсвэл тухайн хүний гэр бүлийн гишүүн нь Компанид хамааралтай бол:

- ✓ Компанийн хяналт эсвэл хамтын хяналттай;
- ✓ Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй;
- ✓ Компанийн гол удирдах боловсон хүчин эсвэл компанийн нэгдмэл гишүүн

### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

#### Холбоотой галууд (үргэлжлэл)

Байгууллага нь дараахь нөхцлүүдийн аль нэгийг мөрдөж байвал дараахь аж ахуйн нэгжтэй холбоотой байна:

- Байгууллага ба Компани нь нэг группын гишүүд (өөрөөр хэлбэл, толгой компани болон охин компани нь бусадтай холбоотой) гэсэн үг юм
- Нэг аж ахуйн нэгж нь бусад аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр (эсвэл бусад аж ахуйн нэгжийн гишүүн байх булгээр ажилладаг хараат компани эсвэл хамтарсан компани) юм
- Аливаа аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хамтарсан компани юм
- Нэг аж ахуйн нэгж гуравдагч этгээдийн хамтарсан компани бөгөөд бусад аж ахуйн нэгж нь гуравдагч этгээдийн хараат компани юм
- Аж ахуйн нэгж нь Компанитай холбоотой аж ахуйн нэгжийн аль алиных нь ажилтнуудын ашиг тусын төлөө ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө Компани өөрөө ийм төлөвлөгөөтэй байгаа бол ивээн тэтгэгч ажил олгогч нь компанитай холбоотой.
- Байгууллага нь Компанийн хяналт, хамтарсан хяналттай этгээдийн хяналтанд эсвэл хамтран хяналт тавьдаг

Байгууллага буюу түүний хэсэг нь аливаа нэг гишүүн нь Компанийн удирдлага эсвэл компанийн толгой компанид удирдах гол боловсон хүчинд үйлчилгээ үзүүлдэг

### 4. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

НББОУС-ын дагуу санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаарх орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тайлагнасан дүн ба болзошгүй өр төлбөрийн тодруулга зэрэгт нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг. Гэвч эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дунд материаллаг дүнтэй залруулга хийхэд хүргэж болно. Ойролцоолсон тооцооллыг хийхэд хэрэглэсэн үнэлэмж, төсөөллүүдийг өөрчлөхөд хүргэж болох үйл явдлууд ирээдүйд тохиолдож болно. Үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдэд орсон аливаа өөрчлөлтийн нөлөөллийг зохистойгоор тодорхойлж болохуйц болсон үед нь санхүүгийн тайлангуудад тусгана.

Төсөөлөл, ойролцоолсон тооцооллуудыг байнга шалгаж үздэг ба эдгээр нь удирдлагын туршлага ба ирээдүйн үйл явдлын талаарх хүлээлт (тухайн нөхцөлд зохистой гэж үзэж байгаа) гэх мэт бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Гэхдээ бодит үр дүн эдгээр ойролцоолсон тооцооллуудаас өөр байж болно.

#### Үнэлэмж

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг хэрэгжүүлэх явцад Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд хамгийн том нөлөө үзүүлэх дараах үнэлэмжүүд (ойролцоолсон тооцооллуудтай холбоотой үнэлэмжүүдээс бусад)-ийг хийсэн. Үүнд:



#### 4. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд (үргэлжлэл)

##### Үйл ажиллагааны түрээс - Компани нь түрээслэгчийн хувьд

Компани түрээсийн гэрээ байгуулсан ба гэрээнд түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл ба өгөөжийг түрээслүүлэгч талд үлдэнэ гэж тодорхойлсон.

Тиймээс түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж бүртгэсэн.

##### Үйл ажиллагааны түрээс – Компани нь түрээслүүлэгчийн хувьд

Түрээслүүлэгч нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаа түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна.

Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээсэлсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө.

##### Тооцооллууд болон төсөөллүүд

Тайлан тэнцлийн өдрийн байдлаар хийгдсэн, дараагийн тайлант жилд хөрөнгийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болзошгүй тооцооллуудын тодорхой бус байдлын ирээдүйн болон бусад томоохон эх үүсвэрүүдийн талаарх гол төсөөллүүдийг дор дурьдав. Компани нь тооцоолол, төсөөллийн параметруудийг санхүүгийн тайлан бэлтгэх явцад үндэслэн гаргадаг.

Одоогийн санхүүгийн байдал ба ирээдүйн хөгжлийн төсөөлөл нь зах зээлийн өөрчлөлт эсвэл Компанийн удирдлагаас үл хамааран өөрчлөгдөж болно. Ийм өөрчлөлтүүд тохиолдсон даруйд төсөөлөл хэсэгт тусгагдана.

##### Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох

Компани нь үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглагдах хугацаа болон ижил төстэй хөрөнгийн салбарын практик болон туршлагын бүлгийн үнэлгээн дээр үндэслэн тооцоолдог.

Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн тооцоолсон ашиглалтын хугацааг тодорхой хугацаа тутамд хянадаг ба биет хорогдол, техникийн болон дансны хуучрал, хөрөнгийг ашиглах хуулийн болон бусад хязгаарлалтуудын улмаас урьдын тооцооллоос хүлээлт нь өөрчлөгдсөн тохиолдолд ашиглалтын хугацаанд өөрчлөлт оруулна.

Дээр дурдсан хүчин зүйлүүдийн өөрчлөлтүүдийн улмаас бий болсон тооцооллын өөрчлөлтүүд үйл ажиллагааны ирээдүйн үр дүнд материаллаг нөлөө үзүүлж болно.

Ямар нэг цаг хугацаанд бүртгэсэн зардлын хэмжээ болон хугацаа нь дээрхи хүчин зүйлс, нөхцөл байдлуудын өөрчлөлтийн нөлөөнд ордог.

Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг бууруулах нь үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх ба эргэлтийн бус хөрөнгийг бууруулдаг.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үндсэн хөрөнгийн дансны үнэ 17,342,740,670.94 төгрөг (2023: 18,181,826,453.62 төгрөг).





Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321